## ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ГҮЙЦЭТГЭХ КОМИССЫН АЖЛЫН БИЕЛЭЛТ

2022 оны 12 сарын 12 Налайх дүүрэг

| Д/д | Төлөвлөгөөт ажил | Биелэлт |
|---|---|---|
| 1 | 2021 оны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, албан хаагчдын баримт бичгийн стандартад хяналт, шалгалт хийх | 2022 оны 04 сарын 04-11-ны өдрүүдэд Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, албан хаагчдын баримт бичгийн стандартад хяналт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж ажилласан. Албан хаагчид ХХНЖ-ын дагуу 2021 онд үүссэн баримт бичгүүдийг Захиргааны ажилтанд хуваарийн дагуу хүлээлгэн өгсөн, баримт бичгийн стандартыг хангаж ажилладаг. 2021 онд байнга хадгалах 32, 70 жил хадгалах 3, түр хадгалах 35, захирамжлалын цахим баримтын 2, цахим ажлын 2, цахим гэрэл зургийн 1, видео дүрс бичлэгийн 1, гэрэл зургийн цомог 29 гээд нийт 105 баримт шинээр үүсч, архивын данс бүртгэлд бүртгэсэн байна. |
| 2 | 2021 оны санхүү, нягтлан бодох бүртгэл, худалдан авалт, хангамж нийлүүлэлтийн ажлын гүйцэтгэлд түүвэр шалгалт хийх | 2022 оны 03 сарын 21-25-ны өдрүүдэд 2021 оны худалдан авах төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, няравын бүртгэл хөтлөлт, баримтын бүрдүүлэлтэнд түүвэр шалгалт хийлээ. Шалгалтаар гарсан зөрчилгүй, анхан шатны баримт бүрдэл хэвийн, 2021 онд 22,921.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 18,842.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж 20,239.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлийг тайлагнасан байна. |
| 3 | 2021 оны Байгууллагын тайлан, Хүний нөөцийн ажлын тайлан, Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний биелэлт, Сургалт хөгжлийн төлөвлөгөөний биелэлт, Ёсзүйн хорооны биелэлт, Мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааны биелэлт, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөөний биелэлт, Удирдах дээд байгууллагаас ирсэн тушаал шийдвэрийн биелэлт зэрэг тайлан, биелэлтүүдийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх | 2022 оны 05 сарын 16-20-ны өдрүүдэд 2021 оны байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт болон хавсралт тайлангуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийлээ. Дотоод үйл ажиллагаатай холбоотой гардаг нийт 12 төлөвлөгөө, биелэлтэд хяналт тавьснаас тайлан биелэлтүүд цаг тухай бүртээ гардаг, хугацаа хоцроосон, зөрчилтэй асуудал байхгүй.<br>- Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан<br>- Хүний нөөцийн ажлын тайлан<br>- Нийгмийн баталгаага хангах төлөвлөгөө, биелэлт<br>- Сургалт хөгжлийн төлөвлөгөө, биелэлт<br>- Ёс зүйн хорооны биелэлт<br>- Мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааний биелэлт<br>- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн төлөвлөгөө, биелэлт<br>- Удирдах дээд байгууллагаас ирсэн тушаал шийдвэрийн биелэлт<br>- Гадаад үйл ажиллагааны тайлан<br>- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт<br>- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө<br>- Архивын ажлын төлөвлөгөө, биелэлт |

| | | |
|---|---|---|
| 4 | Хамтран ажиллах гэрээ байгуулсан байгууллагуудын 2021 оны гэрээний биелэлтэд хяналт шинжилгээ хийх | 2022 оны 02 сарын 14-18-ны өдрүүдэд Парктай хамтран ажиллах гэрээ байгуулсан үйлдвэрүүдийн гэрээний биелэлтэд хяналт шинжилгээ хийсэн. 2021 онд нийт 15 аж ахуйн нэгжтэй шинээр гэрээ байгуулж, нийт 45 ААН хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байна. Гэрээнд тусгасан үндсэн 43 эрх, үүргийн дагуу үйлдвэрүүдийн гэрээг дүгнэж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 10 ААН-тэй хамтран ажиллах гэрээг цуцлаж, 10 ААН-д хугацаат үүрэг даалгавар хүргүүлсэн байна. |
| 5 | 2022 оны эхний хагас жилийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, албан хаагчдын баримт бичгийн стандартад хяналт, шалгалт хийх | 2022 оны 10 сарын 17-21-ны өдрүүдэд 2022 оны эхний хагас жилийн архивын үйл ажиллагаа, стандартад хяналт шинжилгээ хийж, ХХНЖ батлах үйл ажиллагааг зохион байгуулсан. НАГ-ын мэргэжилтэн Баярцэцэгээс ХХНЖ боловсруулах талаар зөвлөмж авч, уг зөвлөмжийн хүрээнд хэлэлцэн баталсан. |
| 6 | Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм журмуудын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, шаардлагатай бол дүрэм журамд өөрчлөлт оруулах санал боловсруулах | 2022 оны 08 сарын 22-26-ны өдрүүдэд байгууллагын дотоодод мөрдөгддөг дүрэм журмуудын хэрэгжилт хяналт үнэлгээ хийсэн. Нийт 17 дүрэм, журам мөрдөгдөж ажилладагаас 2021 онд Албан хаагчдын ёс зүйн дүрэм, Албан хэрэг хөтлөлтийн журмуудыг шинэчлэн баталсан байна. 2021 оны байдлаар дүрэм, журмууд зөрчигдсөн тохиолдол байхгүй, албан хаагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлсөн заалт байхгүй гэж үзсэн. |

ХЯНАСАН:

ДАРГА С.БАТЖАРГАЛ

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Н.ПҮРЭВСҮРЭН

/2022 оны ... сарын ...-ны өдөр/

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

МАРКЕТИНГ, ОНХХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЭНГҮҮН